



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/559

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн Засаг даргын 2018 оны А/240 дүгээр захирамжаар батлагдсан “Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалт болон улсын төрөлжсөн олимпиадын амжилтыг харгалзан урамшуулал олгох журам”-ын 2.2.5, 2.3.3, 4.1, 4.2, 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалт болон улсын төрөлжсөн олимпиадын амжилтыг харгалзан урамшуулал олгох журам”-ын шалгуурыг хангаж элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэлний хичээлээр 800 оноо авч, монгол хэл бичгийн улсын төрөлжсөн олимпиадаас хүрэл медаль хүртсэн Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч Төмөрбатын Цэцэгмаад 1.500.000 (нэг сая таван зуу) төгрөг, монгол хэл бичгийн шалгалтад 800 оноо авсан Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч Төмөрхуягийн Болормаа, математикийн хичээлээр 800 оноо авсан Хархорин сумын ерөнхий боловсролын Гүнзгий сургуулийн төгсөгч Отгонсүхийн Жадамба, нийгмийн тухай мэдлэг хичээлээр 800 оноо авсан Лаборатори Мэргэд сургуулийн төгсөгч Төмөрчөдөрийн Гийхнаран, Ширчиндиваагийн Ичинхорлоо, Буянбадрахын Нандин-Эрдэнэ нарт тус бүр 1.000.000 (нэг сая) төгрөгийн сургалтын төлбөрийн урамшуулал олгосугай.

2. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд олгох нийт 6.500.000 (зургаан сая таван зуун мянга) төгрөгийн мөнгөн урамшууллыг ерөнхий боловсролын багцаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100986